

МУИС-ИЙН 80 ЖИЛИЙН ТҮҮХЭН ДЭХ ФИЛОСОФИЙН СУРГАЛТ, СУДАЛГААНЫ АГУУЛГА, АРГА ЗҮЙН ӨӨРЧЛӨЛТ*

*Профессор М.Отгонбаяр, доктор (Ph.D)
Зөвлөх профессор Ц.Гомбосүрэн, доктор (Sc.D)
МУИС, Философи, шаашин судлалын тэнхим*

Түлхүүр үг: философийн сургалт, судалгаа, хөтөлбөрийн шинэчлэл, философийн бүрэлдэхүүн, философийн түүх.

МУИС үүсэн байгуулагдсанаасаа хойших 80 жилийн туршид шинжлэх ухаанд оруулж ирсэн үр дүндээ үнэлгээ өгч буй үйл ажиллагаанд тэнхмүүд маань ямар хувь нэмэр оруулснаа дүгнэж буй үед манай тэнхим ч гэсэн энэ үйл ажиллагаанд мэргэжлийнхээ судалгааныхаа ололтын үүднээс хандаж байдаг.

Олон арван жилээр манайд тогтсон нэр томъёогоор бол тэнхмийн маань судалгаа, сурталчилгааны үйл ажиллагаа нь “шинжлэх ухааны” гэдэг тодотголтойгоор хэвшсэн билээ. Гэтэл угтаа “шинжлэх ухаан” гэдэг үг нь түүнийг онолын нэр юм уу онолын тодотгол болгон ашигладаг улс орнуудад үгийн сангийн ч, бас онолын ч утга нь өөр санаа илэрхийлдэг. 1992 онд улс маань шинэ үндсэн хуультай болсноор бид нийгмийн асуудлыг, түүний дотор түүхийн асуудлыг философийн монизмд баригдалгүйгээр плюралист үзэл, аргагүйгээр авч үзэх хууль-эрх зүйн баттай үндэстэй болсон билээ. Улмаар хүн төрөлхтний мэдлэгийн бүрэлдэхүүн дотроос хэрэг дээрээ зөвхөн шинжлэх ухааныг туйлчилдаг, тэгээд бас шинжлэх ухааныг гагцхүү өөрийнхөө сургаалд захируулан сурталчилдаг марксист-ленинист монист тайлбараас ангижрах судалгаа явуулахад манай тэнхмийнхэн монголчуудаа, тухайлбал нийт мэргэжил нэгтнүүдээ оройлон түүчээлсэн билээ. Тэгээд судалгааныхаа үр дүнд хамт олон маань орчин үеийн философи дахь онолын

болон арга зүйн чухал чухал мэдлэгийг эзэмшсэнээс гадна өөрсдөө ч зарим чухал дүгнэлт хийн томъёолол боловсруулж, тэр бүгдээ сургалт, сурталчилгаандаа болон дараа дараачийн судалгаандаа баримталж байна.

Бид Монгол улс дахь философийн мэргэжлийн сургалт, судалгааны ажлыг ХХ зууны 90-ээд оноос өмнөх ба 90-ээд оноос хойших гэсэн онол, арга зүйн хувьд эрс ялгаатай хоёр үе шатанд хуваан үзэж байна.

1990-ээд оноос өмнөх үеийн Монгол дахь философийн сургалт, судалгаа агуулгын хувьд диалектик ба түүхийн материализм, шинжлэх ухааны коммунизмын онолын сэдэв зонхилсон, арга зүйн хувьд материалист диалектикийг хатуу баримталсан шинжтэй байв. Энэ бол тухайн үе дэх Монгол төрийн эрх баригч бүхий намын коммунист үзэл суртлын цор ганц зэвсэг болох марксист-ленинизмийг хатуу баримтлахаас өөр аргагүй түүхэн нөхцөл байдлын үр дүн юм. Социалист байгуулалтын он жилүүдэд дээрээс доош чиглэлтэйгээр МАХН-аас явуулсан марксист, коммунист сургалт, сурталчилгааны үр дүнд манай онолын салбарынхан улс төрийн албадлагын эрхээр төдийгүй бүр итгэл үнэмшлийнхээ үүднээс марксист-ленинизмд тууштай, үнэнч ханддаг байв.

1992 онд Монгол Улс хөгжлийн ардчилсан замыг сонгосон шинэ Үндсэн хуультай болсноор бид метафизик,

онтологи, эпистемологи, нийгэм, улс төр, түүх, соёл, шашны зэрэг философийн асуудлыг марксист биш онол, аргазүйгээр авч үзэх эрх зүйн үндэс бүрдсэн билээ. Улмаар хүн төрөлхтний онолын мэдлэгийн бүрэлдэхүүн дотроос зөвхөн шинжлэх ухааныг туйлчилдаг, тэгэхдээ шинжлэх ухааныг гагцхүү өөрийнхөө сургаалд захируулан сурталчилдаг марксист-ленинист тайлбараас ангижрах судалгаа явуулах, түүнээ сургалтанд нэвтрүүлэх ажилд манай тэнхмийнхэн нийт мэргэжил нэгтнүүдээ түүчээлсэн юм. Тэгээд судалгааныхаа үр дүнд манай хамт олон орчин үеийн философийн онолын болон арга зүйн мэдлэгийг шинээр эзэмшсэнээс гадна, өөрсдөө ч зарим чухал дүгнэлт хийн, томъёолол боловсруулж, тэр бүгдээ сургалт, судалгаандаа баримталж ирэв.

Манай тэнхим философийн мэргэжлийн хөтөлбөрийг орчин үеийн дэлхийн их сургуулиудын жишиг, түвшинд нийцүүлэн өөрчлөх ажлыг 90-ээд оны төгсгөл үеэс эрчимтэй эхлүүлж, улмаар тэнхимийн зарим багш нарын үүсгэн байгуулсан Нээлттэй Философи нийгэмлэг гэдэг ТББ-аас Монголын Нээлттэй нийгэм хүрээлэн (Соросын сан)-ийн санхүүжилтээр 1998 оны 6 дугаар сард “Философийн сургалт ба арга зүйн сонголтын эрх чөлөө” сэдвээр Философичдын улсын симпозиумыг анх удаа зохион байгуулсан юм. Тус симпозиумд оролцогчдоос Монгол Улсын Гэгээрлийн Яам, бүх их, дээд сургуулиудад хандсан зөвлөмж гаргаж, түүндээ философийн сургалтанд янз бүрийн арга зүйн сургаалыг плюралист байр сууринаас сурталчлах нь оюутнуудад философи мэдлэгийг эзэмшүүлэх чухал баталгаа мөн гэсний зэрэгцээ их, дээд сургуулийн философийн сургалтын агуулгыг шинэчлэх чиглэлийг тодорхойлсон буй.

МУИС-ийн Философийн Тэнхим Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэнтэй хамтран философийн сургалтын арга зүй,

практикийн асуудлаар улсын семинарыг 2000 оны 2 дугаар сард зохион байгуулсан юм. Тус арга зүйн семинараас ерөнхий суурь философийн хичээлийн агуулгын стандарт ямар байх талаар нэгдсэн шийдвэр гаргасан байна.

2014 онд МУИС-ийн сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд шинээр боловсруулсан философи хөтөлбөрийг дэлхийн их, дээд сургуулиудын философи хөтөлбөрийн стандарт, шаардлагад нийцүүлэн бүтэц болон агуулгын хувьд өөрчилсөн юм.

Ийнхүү өнгөрсөн зууны 90-ээд оноос эхэлсэн философийн хөтөлбөрийн өөрчлөлтийн үйл явц бараг 20 гаруй жил үргэлжилсэн бөгөөд 1990-ээд оноос 2010 он хүртэлх үе бол философийн мэргэжлийн хөтөлбөрийг орчин үеийн дэлхийн их сургуулиудын философийн мэргэжлийн хөтөлбөртэй нийцүүлэн шинэчлэх шилжилтийн үе байсан юм. Философийн салбарын судалгааны сэдэв, арга зүй хөтөлбөрийн өөрчлөлттэй холбоотойгоор шинэчлэгдэн өөрчлөгдсөн байна.

XX зууны 90-ээд оноос хойшхи үеийн Монголын философи дахь сургалт, судалгааны өөрчлөлтийг (1) Философи гэж юу болох, (2) Философи мэдлэгийн бүрэлдэхүүн, чиглэлүүд, (3) Философийн түүхийн үечлэл: сонгодог биш философи гэсэн хэсгүүд тус бүрээр авч үзэхийг зорив.

Философи гэж юу вэ?

Материалист монизм ноёрхож асан түүхэн үед үнэн бөгөөд ашигтай мэдлэг бол танин мэдэхүйн үр дүн, тухайлбал онолын төвшинд зөвхөн шинжлэх ухааны үр дүн гэдэг үзэл манай бүх төрлийн судалгаа, сургалт, сурталчилгааны үзэл санааны нь үндэс болж байлаа. Тийм үзэл, байр суурь нь шинжлэх ухаан бол орчин үеийн мэдлэгт яндашгүй үнэ цэнэтэйг илэрхийлсэн зүйтэй талтай. Гэхдээ өөрийнхөө философийг шинжлэх ухаануудын шинжлэх ухаан хэмээн

өргөмжилсөн Гегелийн рационализмыг марксизм-ленинизм үзэл санааны нэг эх сурвалжаа болгож, марксизмын нэг бүрэлдэхүүн болох философи бол диалектик материализм ба түүхийн материализм гэдэг салшгүй уялдаат хоёр хэсгээс бүрдсэн цорын ганц үнэн, зөв, шинжлэх ухаанч философи сургаал мөн хэмээн сурталдаж ирсэн юм. Марксист-ленинист философи, марксист-ленинист ёс зүй, марксист-ленинист гоо зүй, шинжлэх ухааны шашингүйн үзэл зэрэгтээ оюуны соёлын үзэгдлүүдийн тухай авч үздэг байсан боловч тэдгээр нь нийгмийн амьдралын холбогдох үзэгдэлд утга оноож, үнэлгээ өгдөг тийм бие даасан мэдлэгийн төрөл мөн болох тухай дурсдаггүй байлаа.

Эдүгээ манай философичдын зарим нь, түүний дотор албан ёсны өндөр нэр хүндтэнгүүд марксист-ленинист философи (МЛФ)-ийг “шинжлэх ухаан” гэдэг социализмын үеийн тунхгаа хадгалсаар байгаа нь аман ба бичгийн холбогдох бичвэрүүд, тайлбарт нь илэрдэг. Харин “марксист-ленинист” гэдэг тодотголоо хэрэглэдэггүй нь зориуд уу үгүй юү? гэдгийн учрыг мэдэхгүй байна.

Философийн судлах зүйл ба философийг тодорхойлох тухай асуудлаар профессор Ц.Гомбосүрэн (1990) “Философийн судлагдахууны тухай асуудалд” өгүүлэлдээ Германы философич В.Виндельбандын “философи гэж юу болох тухай нэгдмэл ойлголт байх бололцоогүй” гэснийг иш татаж, гэхдээ эндээс философийн тухай ерөнхий, нэгдмэл ойлголт бий болж чадахгүй гэсэн дүгнэлт гарах албагүй гээд философийн тухай нэгдмэл, ерөнхий тодорхойлолт гаргах гэж оролджээ. Философи бол хүний орших аргыг тодорхойлогч нэг юмуу хэд хэдэн хүчин зүйлийг зориуд, шууд юмуу тийм бишээр тодорхой нэг шинжлэх ухааны хүрээнээс халин ямар нэг байдлаар авч үзэн, судалдаг өөр өөр сургаал мөн” гэсэн интеграль оролдлого хийжээ (р. 11).

Доктор Б.Батчулуун (2004) “философи бол хэн нэг хүний санаан зоргоороо ямарч категори, терминий түвшинд боловсроогүй зүйл ярьчихаад “энэ бол миний философи” гэдэгтэй адилгүй зүйл” хэмээн философийн категорилаг, ердийн биш, онолын түвшний мэдлэг болохыг онцолсон байна (р. 32).

Дэлхийн философийн өдөрт зориулан МУИС-ийн Философийн тэнхимээс 2005 онд зохион байгуулсан эрдэм шинжилгээний хуралд тавьсан “Метафилософи зарим эргэцүүлэл” илтгэлдээ миний бие сонгодог биш ба сонгодог бишийн дараах үеийн нэр хүндтэй олон философичдын холбогдох үзлийг авч үзсэн юм (М.Отгонбаяр, 2007). Философи гэж юу вэ? Философийн асуудал гэж юу вэ? Философийн асуудлууд нь түүх, шинжлэх ухаан, урлаг, шашны асуудлуудаас ямар ялгаатай вэ? Хэрэв философийн асуудлууд нь өөр өөрийн утгатай бол тэдгээрийн хариулт нь ч судалгааны бусад хэлбэрүүдэд ердийн замаар бууж ирэх тийм утгатай байх уу? Философийн уг чанарын тухай иймэрхүү төрлийн асуултуудад философичид янз бүрээр хариулж ирсэн бөгөөд метафилософи энэхүү ялгаа нь философийн ойлголтууд, хэлбэр, чиглэл дэх ялгаанаас шууд урган гарч буй юм. Үнэхээр ч зарим философичдын хоорондын метафилософи ялгаа бол философийн тухай үл зөвшилцөл болох тэдний ялгаатай үзлийг авч үзэх нийтлэг хөрс суурь огт алга гэхээр тийм хэт байна гэхэд хэтрүүлэг болохооргүй юм. Зарим философичид философи бол ялгаатай философи ойлголтуудын тухай хэллэгүүдээс тогтох тусгай судлах зүйлтэй хэмээх үзлийг эрс няцаадаг байхад бусад нь эл үзлийг дэмждэг. Зарим нь мэдлэгийн бусад салбаруудынхаас өөр категоритай учраас философийн зорилго бол маш өвөрмөц ялгаатай гэдэг. Философи бол эсвэл гагцхүү санааг цэвэршүүлэхийг оролддог гэх, эсвэл алдаатай, бүрхэг ойлголтуудыг өөрсдийн хөгжсөн санаагаар сольсноор бусад субъект болон хүний үйлийн бусад

төрлүүдэд эерэг хувь нэмэр оруулдаг гэх зэрэг нь метафилософийн чухал сэдвүүдэд багтах юм.

Доктор Г.Цэрэн (2012) “Философи гэж юу вэ?” нэртэй өгүүлэлдээ философийн гол зорилго бол юмсыг танин мэдэхээсээ илүү ухааран ойлгоход чиглэсэн байдаг” гэжээ (р. 41).

Ийнхүү манай тэнхмийн мэргэжлийн практикт философи бол онолын үнэлэмж мөн, философи бол шинжлэх ухааныг онолын нэг уг сурвалжаа болгодог хэдий ч, эцсийн үр дүнгээрээ онолын үнэлэмжийн нэг бүрэлдэхүүн мөн гэж үзэж байна. Үнэлэмж бол мэдлэгийн бие даасан нэг бүрэлдэхүүн, тухайн нэг юм уу бүлэг хүмүүс болох субъект өөрийнхөө мэдлэг, итгэл үнэмшил, байр суурь, сонирхол зэргийнхээ үүднээс ухааран ойлгож, ямар нэг байдлаар үнэлэн цэгнэдэг хүн төрөлхтний мэдлэгийн зайлшгүй нэг төрөл мэдлэг мөн. Танин мэдэхүй, тухайлбал шинжлэх ухаан үнэнийг нээх зорилготой байдаг бол үнэлэмж бол үнэн гэж итгэсэн мэдлэгт шашин, философи, ёс суртахуун, урлагийн мэдрэмж зэргийн аль нэгний нь юм уу зарим хэдийнх нь үүднээс үнэлгээ өгдөг үйл бүхий байдаг. Товчоор хэлбэл танин мэдэхүй, үнэлэмж хоёр нь зорилго болон агуулгаараа ялгаатай боловч нэг нь нөгөөгийнхөө харилцан шалтгаан болж байдаг тус тус бүрэлдэхүүн мөн.

Философи мэдлэгийн бүрэлдэхүүн, чиглэлүүд

Марксист-ленинист философи бол диалектик ба түүхийн материализмаас бүрдсэн цорын ганц үнэн бөгөөд зөв онол, арга мөн хэмээн үзэж ирсэн учраас тухайн үеийн философийн сургалт, судалгааг диалектик арга, танин мэдэхүйн диалектик зам, түүхийг үзэх материалист үзэл, нийгэм эдийн засгийн формац зэрэг сэдвүүд бүрдүүлж байв.

XX зууны 90-ээд оноос эхэлсэн

философийн мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн бүтэц дэх хичээлүүдийн нэршлийн өөрчлөлтийг авч үзвэл (М.Отгонбаяр. 2021.)

- Диалектик материализм-ын хичээл “материалист” хэмээх тодотголоо орхин “Диалектик” гэсэн нэртэй болж 90-ээд оны төгсгөл хүртэл заагдсан ба мөн үеэс түүний оронд “Метафизик ба онтологи” гэдэг хичээл шинээр орж эхэлжээ. Логик, математик логик, танин мэдэхүйн онол, шинжлэх ухааны философийн хичээлүүд мэргэжлийн заавал үзэх хичээлийн ангилалд багтжээ.

- Философийн түүх эртний, дундад зууны, германы сонгодог, орчин үеийн өрнөдийн философи гэсэн ангиллаар задарч, багц хичээл болжээ. Мөн 90-ээд оны дунд үеэс философийн түүхийг өрнө, дорно гэсэн ижил үнэлэмж бүхий хоёр хэсэгт хуваан, түүхийн үе шатуудаар бүлэглэж зааж эхэлсэн байна. Урьд нь европ төвт философийн түүхийг судалдаг байсныг ийнхүү халсан юм.

- Түүхийн__материализм-ын хичээл “Нийгмийн философи”, “Улс төрийн философи” нэртэй болон агуулга, арга зүйн хувьд өөрчлөгдсөн. XXI зууны эхэн үеэс улс төрийн, эрх зүйн, түүхийн зэрэг салбар философи хичээлүүд сонгон судлах хичээл байдлаар хөтөлбөрт оржээ.

Марксист - Ленинист ёс зүй, Марксист-ленинист гоо зүйн хичээл марксист-ленинист гэсэн тодотголоо орхин Ёс зүй, Гоо зүй, Шинжлэх ухааны шашингүйн үзлийн түүх ба онол гэдэг хичээл Шашин судлал гэсэн ерөнхий нэртэй болон мөн агуулга, арга зүйн хувьд өөрчлөгдсөн юм.

Ийнхүү өнгөрсөн зууны 90-ээд оноос эхэлсэн философийн мэргэжлийн хөтөлбөр дэх философийн урсгал, чиглэлүүд агуулга, арга зүйн хувьд эрс өөрчлөгдөж, улмаар өнөөдрийн Философи мэргэжлийн хөтөлбөр бүх түвшинд дараах бүтэцтэй болсон. Үүнд:

1. Философийн онолын хүрээнд Логик, Метафизик, Онтологи, Танин мэдэхүйн онол, Шинжлэх ухааны философийн хичээлүүд зааж байна.
2. Философийн түүхийг Эртний грек ромын, Дундад зууны, Сэргэн мандалтын, Шинэ үеийн ба Орчин үеийн өрнөдийн философи гэсэн үечлэлээр зааж байна. Философийн түүхийг өрнө, дорно гэсэн ижил үнэлэмж бүхий хоёр хэсэгт хуваан, судалж байна.
3. Практик философийн салбарт Ёс зүйн салбар Ёс зүйн удиртгал, Хэрэглээний ёс зүй, Мета ёсзүй, мөн Гоо зүй, Урлагийн философи, Үнэлэмжийн онол гэсэн чиглэлээр хөтөлбөр боловсруулсан зааж ирэв. Мөн Түүхийн философи, Эрх зүйн философи, Боловсролын философи, Соёлын философи, Шашны философи, Урлагийн философи, Хүний тухай философи зэрэг салбарын философи чиглэлүүдээр сургалтын хөтөлбөр шинээр боловсруулан бүх түвшинд хичээл заах, судалгаа хийх, мэргэжлийн ном зохиол орчуулах зэрэг ажлыг бид хийж байна.

Философийн түүхийн үечлэлийн асуудал

Өнгөрсөн тогтолцооны үед үзэл сурталдаа захируулан философийн түүхийг а). Марксаас өмнөх үеийн философи, б). Марксист – ленинист философи, в). Орчин үеийн хөрөнгөтний философи чиглэлүүд хэмээн гурван үед хуваан зааж ирсэн юм. Марксист философитой зэрэгцэж болон түүнээс хойш үүсэн, оршиж байгаа философи чиглэлүүдийг “хөрөнгөтний”, “харгис” хэмээн шүүмжилдэг байлаа.

Өнөөдөр бид түүхэн дэх философи чиглэлүүдийг философидолтынх нь өвөрмөц хэв маягийг үндэслэгээ болгон а). сонгодог философи, б). сонгодог биш философи, в). сонгодог бишийн дараах философи гэсэн ангиллаар философийн

түүхийн сургалт, судалгааг явуулж байна.

Сонгодог философийн тухай бидний мэдлэг дэх шинэ уур амьсгал

- Сонгодог философид онтологийн үүднээс ахуй, ухамсар хоёрын, харин танин мэдэхүйн хүрээнд мэдлэгийн объект (оногдохуй), субъект (онохуй) хоёрын аль нь алиныгаа тодорхойлдог тухай асуудал чухал байж, бинар эсрэгцэлт шийдвэр гаргадаг. Сонгодог философийн онтологи бол материализм, идеализм гэдэг хоёр л чиглэлтэй хэмээн марксист–ленинист философи сурталчилж ирсэн, тухайлбал В. И. Ленин: идеализм бол шашны суртлын чимэглэсэн хэлбэр, харин шашин бол идеализмын болхи хэлбэр мөн гэсний дагуу марксист–ленинист философи шашны философийн онтологийг идеализмд хамруулж ирсэн түүхтэй. Харин бид шашны философийн онтологийн бие даасан байдлыг үндэслэн зөвтгөж, түүнээ зарим маань “шашны трансцендентализм”, зарим маань “шашны онтологи” гэх мэтээр нэрлэдэг болов.
- Контын позитивизм, неопозитивизм дахь верификацийн зарчим, постпозитивизм дахь фальсификацийн зарчим, натуралист баримтлалууд (тухайлбал газарзүйн детерминизм, Мальтусын онол, социаль дарвинизм, экологийн философийн олон сургууль, Гумилевийн боловсруулсан пассионари онол) зэргийг марксист–ленинист философийн үүднээс “идеалист” хэмээн цоллодог боловч угтаа материалист хандлагатай онол болохыг үндэслэв.
- Марксист–ленинист философи материаллаг ахуйн хамгийн ерөнхий хүрээг илэрхийлсэн “матери” гэдэг категорийг үндсэн ойлголтоо болгодог. Харин эдүгээ бид сургалт, судалгаандаа “матери”, “байгаль”, “нийгэм”, “хүн”,

“хүний үйлдэл” гэдэг философи хэрэглээний нэршлээр илэрдэг категориудын агуулгыг онцлон шинээр тайлбарлаж байна.

- Шинэ үеэс хойш ялангуяа XIX зуунд Гегелийн диалектик бий болсноос хойш аргын тухай онол бол сонгодог философийн нэн чухал бүрэлдэхүүн болсон нь марксист–ленинист философид хамгийн шууд холбогддог. Аргагүйн хувьд материалист диалектикийн нэг гол дутагдал бол энэ философи сургаал нь бодит байдлын аль нэг юм уу зарим хэдэн үзэгдэлд объектив байдаг шинжийг бодит байдалд бүхэлд нь нийтлэг хүчинтэй хэмээн туйлшруулдаг. Бас энэ диалектик бол монист шинжтэй. Философид диалектик ба метафизик хоёр арга тэмцэлдэн оршдог хэмээн марксист–ленинист философи сурталчилж ирсэн шиг метафизик гэгч нэг арга байдаггүй бөгөөд янз бүрийн философийн боловсруулсан жич жич гүйцэтгэл бүхий жич жич арга танин мэдэхүйн болон үнэлэмжийн ямар нөхцөлд эерэг гүйцэтгэлтэйг суралцагчдад эзэмшүүлэх нь чухал болохыг үндэслэсэн.
- Сонгодог философи үеэ өнгөрөөсөн тухай позитивизм бүр XIX зуунд зарласан ч, XX зуунд сонгодог философиос судлахуун ба агуулгаараа ялгаатай өч төчнөөн философи үүсэн оршиж буй боловч сонгодог философийн шинэ шинэ хэлбэр үүсэн орших ертөнцийг үзэх үзлийн болон онолын уг сурвалж өнөө ч үргэлжлэн байна.

Сонгодог биш философийн талаарх судалгааны практик өгөөж

Өмнөх тогтолцооны үед энэ философийн чиглэлүүдийг марксист–ленинист философийн үүднээс “хөрөнгөтний” хэмээн зөвхөн шүүмжилдэг байсан билээ. Харин

өнөөдөр бид сонгодог биш философийн нөлөө бүхий бүх чиглэлийг сургалтын хөтөлбөртөө оруулж, бүх түвшний сургалтын мэргэжлийн заавал болон сонгон судлах хичээлийн ангилалд оруулсан нь судалгааны ажлын шинэ шинэ сэдвүүдийг төрүүлсэн юм.

Сонгодог биш философийн аль ч чиглэлийг суралцагчдад эзэмшүүлэх нь нэгд, тухайн чиглэл нь сонгодог философи шиг ертөнцийг бүхэлд нь ямар нэг ерөнхийн үүднээс авч үзэлгүйгээр харин хүн төрөлхтний сэтгэх, мэдрэх, хэлэх ба ярих, бүтээх юм уу эвдэх, эвсэх юм уу зөрчилдөх, хадгалах юм уу хэрэглэх, урлах юм уу сарниах, орших юм уу үгүй болох гэх мэт нэн олон талт үйлдлийн аль нэгийг юм уу зарим хэдийг онцлон философиддог. Тиймээс сонгодог биш философийн аль ч чиглэл нийгмийн амьдралын, тухайлбал соёлын амьдралын харгалзах салбарт сонгодог философийн чиглэлүүдээс илүү наалдацтай хэрэглэгддэг.

Хоёрт, сонгодог философийн олон нэрт төлөөлөгч өөрийнхийгөө бусдынхаас салгасан жич жич арга боловсруулсан түүхтэй. Угтаа тэдгээр нь харилцан бие биеэ шаардаж, баяжуулж, сэлбэдэг зэрэг уялдмал харилцаатайг үндэслэн заасан нь Гегелийн диалектикийн нэг ололт ба гавьяа ажээ. Гэхдээ Гегелийн диалектик бол олон судлаачийн илрүүлсэн дутагдлууд бүхийг сонгодог биш философийн янз бүрийн чиглэлийн боловсруулсан аргууд тус тусынхаа үүднээс цагаатгасан ололттой байдаг. Тийм бүх цагаатгалыг дэмжсэн үнэ цэнэтэй аргазүйг сонгодог биш философи бий болгосон нь “анархист аргазүй”, “аргазүйн анархизм” гэх нэртэй. “Аливаа аргын шаардлага гагцхүү нарийн томъёолсон нөхцөлд зөв байж, бусад нөхцөлд тийм байж чаддаггүй. Шинжлэх ухаан дахь эрс нээлтүүд бол аргазүйн тогтсон дүрэм, шаардлагыг зөрчин байж гардаг” гэдгийг энэ аргазүйд үндэслэл

болгодог.

Сонгодог бишийн дараах философи

Энэ бол структуралист, монгол хэл рүү орчуулбал бүтэцчилэх философи баримтлалуудыг хянан өөрчилсний үр дүнд ХХ зууны 70-80-аад онуудад анх Францад, дараа нь Өрнөдийн бусад олон оронд үүсэн дэлгэрсэн “постструктурализм” нэртэй философидолт ба бараг тэр даруйд энэ философидолтыг гол нь сэдвийн хувьд залгамжилж, гэхдээ түүний бие даасан бүтэц ба агуулгыг нь алдагдуулаагүй үүссэн “постмодернизм” нэртэй философидолт хоёрын холбоо юм.

Сонгодог бишийн дараах үеийн философийг зөвхөн ХХI зуун гарснаас хойш Монголд аягүй бол анх удаа сургалт, судалгааныхаа нэг объект болгосон манай тэнхим нэр томъёо, агуулга, аргазүйд холбогдох дараах мэдээлэл ба үндэслэлүүдийг чухалчлан сурталчилж байна.

Энэ онолыг бүтээгч нар түүнийгээ “философи” гэдэггүй, харин “философидолт” гэдгийн шалтгаан бол тэд өөрсдийгөө систем зохиогоогүй, түгээмлийн тухай үзэлд ороогүй, харин тус тус асуудлаарх үндэслэл боловсруулсан хэмээдэг.

Структурализмын нэлээд хэдэн үндэслэлд шүүмжлэлтэй хандан, тэдгээрийг засварлах замаар постструктурализм үүссэн байна. Тухайлбал нэгдүгээрт, структуралистууд судалгааны объектдоо тэмдэглэгдэгч, тэмдэглэгч хоёрын тодорхой харилцаа холбоон дахь статик цэгц байдал, хос эсрэгцэл, зүй тогтол, логик байгууламж зэрэг бүтэцлэг зүйлсийг онцолсон байдаг. Харин постструктуралистууд үүний эсрэг бүтцийн хүрээний гаднах түүх ба динамик, янз янзын тохиолдол, учрал, жич жич үйл явдал, эрх чөлөө,

захирах захирагдах харилцаа, эрх мэдэл, мөн цухалдал (аффект) зэрэг бүтэцлэг биш зүйлсийг онцолжээ. Энэ нь нийгмийн дэг журам, хууль ёс, шинжлэх ухааны мэдлэгт үндэслээд нийгмийг шинэчлэн сайжруулах, нийгмийн амьдралын ирээдүйг угтан харах бололцоонд постструктуралистууд эргэлзсэнийх нь онолын ба арга зүйн илэрхийлэл мөн ажээ. Хоёрдугаарт, тэмдгийн тогтолцоонд тэмдэглэгдэгч нь тэмдэглэгчээ тодорхойлдог хэмээн бүтэцчилэх онол (структурализм) үздэг. Ийм үзлийг постструктуралистууд үл зөвшөөрөөд, тэмдэглэгчээсээ тэмдэглэгдэгч нь хамаардаг гэж үзсэн. Ийм үзлийнхээ үүднээс шинжлэх ухааны категориуд бол ахуйг гуйвуулан илэрхийлдэг янз бүрийн дүгнэлт мөн гэдэг.

Постмодернизм бол постструктурализмын чухал чухал үндэслэлд шүүмжлэлтэй хандаж, улмаар тэдгээрийг шинэ агуулгатай болгосны үр дүн болж үүсчээ. Гэхдээ олон судлаач философийн салбарт дан ганц “постмодернизм” гэж ярихыг учир дутагдалтай гэж үзээд оронд нь өмнө дурдсанчлан “постструктуралист-постмодернист нэгдмэл цогцолбор” эдүгээ төлөвшсөн тухай ярихыг тохиромжтой гэж үзэн зарим үндэслэгээ гаргадаг. Тухайлбал нэгдүгээрт, ХХ зууны 80-аад онуудад алдартай олон философич постструктурализмын үүднээс боловсруулсан үндэслэлүүдээ постмодернизмд шилжсэн үедээ бас уламжлан баримталжээ. Үүнд: нийгмийн амьдрал эмх замхгүй байдаг тухай; хүн төрөлхтний түүх бол объектив зүй тогтолт шатууд өмнөхөө дараахь нь халах үйл явц биш, харин тохиолдлуудын хэлхээ мөн байдаг тухай; нэр хүнд ба уламжлалт үнэлэмжүүдэд хүмүүс итгэхээ больж

байгаа тухай; бодит байдал бүхэлдээ ба тодорхой хэсгүүдээрээ бүгд текст мөн тухай зэрэг постструктурализмын олон чухал баримтлал постмодернизмд уламлагдсан аж. Хүн бол орчлонгийн төв мөн гэж үздэг аль Сэргэн мандалтын үеэс эхлэлтэй гуманист уламжлалыг постструктурализм хүлээж аваагүйг постмодернизм үргэлжлүүлэн бататгажээ. Хоёрдугаарт философи зэрэг хүмүүнлэгийн бүх ухаанаар зогсохгүй байгалийн шинжлэл зэрэг орчин үеийн мэдлэгийн янз бүрийн төрлийн хүрэн дэх онолын баримтлалуудыг бий болгодог үндсэн талбар бол уран сайхан хэллэг мөн гэж постструктурализм, постмодернизм аль аль нь үзжээ. Гуравдугаарт, утга зохиол судлал бол постструктурализм, постмодернизм хоёрын аль алины нь философидолтын объект ба арга болдог.

Ийнхүү постструктурализм, постмодернизм хоёр агуулга ба арга зүйн тодорхой хэсгүүдээрээ нийлж, нэгдмэл нэг цогцолбор болдогийн зэрэгцээ постмодернизмд постструктурализмаас ялгагдах чухал чухал философи үзэл, зарчим байдаг. Тухайлбал тэмдгийн тогтолцоонд тэмдэглэгдэгч, тэмдэглэгч хоёр ямар харьцаатайн тухай асуудлыг структурализм, постструктурализм хоёр бие биеийнхээсээ эсрэгээр эрс шийвэрлэсний аль алиныг постмодернизм үл баримталж, нөхцөл байдлаас хамаарч аль ч шийдвэр нь хүчинтэй байх бололцоог зөвтгөжээ. Сонгодог бишийн дараах шинжлэх ухаан, постмодернизм хоёр харилцан нэгнийхээ онолын үндэс болж байна.

Философийн өнөөгийн төлөв байдал

Технологижиж глобальчлагдсан өнөөгийн нийгмийн амьдрал дахь философийн байр суурь нь нэг талаас практик асуудлуудтай илүү холбоотойгоор мэргэшин салбарлалт, нөгөө талаас орчин

үеийн шинжлэх ухаан, технологийн дэвшилтэй холбоотойгоор логик, математик, шинжлэх ухааны хэлний хэрэгцээ ба онолын философийн асуудлуудын комплексжилт гэсэн интернал болон экстернал хүчин зүйлсээр нөхцөлдсөн тун хэцүү цаг үед байна.

Онолын мэдлэгийн аль нэг төрөл монополь байр суурь эзлэх тухай асуудал үеэ өнгөрөөсөн өнөө үед утга холбогдлын концептуаль схемд лингвистик эргэлт гарсан. Метафизик, онтологийн төдийгүй эпистемологи, этик, эстетикийн уламжлалт бүх асуудлууд өнөөдөр референцийн концептуаль системийн үүднээс асуудалтай болсон хэдий ч, а.) философийн анхны зорилтыг эргэн харах, б.) философийн эрэл хайгуулд шинэ шинэ зорилтыг олж харах, в.) философи өөрийн амин чанараараа тэсэж үлдэх гэсэн боломжуудыг олгож буй давуу талтай юм.

Коммунист системийн гишүүн байсан Монгол улсын тухайд философийн мэргэжлийн сургалт, судалгаанд нэг талаас философийн онолууд, түлхүүр асуудлуудыг шинээр авч үзэх, тэдгээрийн сонгодог биш утгыг нь тодруулах шаардлага тулгамдаж байна. Нөгөө талаас посткоммунист орнуудад ноёрхож асан марксист философитой холбоотойгоор догматикаар хүлээн авч, тайлбарлаж ирсэн ойлголтуудын утга болон утга холбогдлыг дахин авч үзэж, тайлбарлах шаардлагатай байна.

Дэлхийн иргэн (өндөр хөгжилтэй, хөгжиж буй, ядуу буурай орны) хэн бүхэнд философиос олж авах дараах мэдлэг, чадварууд өнөөдөр чухал хэрэгцээтэй хэвээр байна.

Үүнд:

- Мадаггүй ба магадлалт эргэцүүлэл, дүгнэлтийг ялган ойлгох чадвар буюу логикийн үнэ цэнэ;
- Утга учиртай, тогтвортой, зөв, сайхан

амьдралын асуудал буюу этик, эстетикийн үнэ цэнэ, улмаар шударга ёс, зүй ёс, эрх чөлөө, тэгш байдал гэх мэт улс төр, эрх зүйн үнэлэмж;

- Бодит байдал, мэдлэг, үнэн зэрэг метафизик, онтологи, эпистемологи асуудлуудын үнэ цэнэ зэрэг болно.

Философийг судалснаар хүний оюун ухаан олон төрлийн алдаа, төөрөгдлөөс салж, бие даан, шүүмжлэлтэй сэтгэн бодох аргыг эзэмшдэг бөгөөд энэ нь нийгэмд чөлөөт сэтгэлгээг эрхэмлэсэн, хараат бус, өөрийн гэсэн өвөрмөц үнэ цэнийг танин мэдсэн, оюуны хувьд аливаа шинэ зүйлд нээлттэй, бүтээлч иргэдийг төлөвшүүлэхэд тус дэм үзүүлдэг билээ.

Ном зүй

1. Гомбосүрэн, Ц. (2019) *1990-ээд оноос хойшхи Монголын философийн амьдрал* (нэгдүгээр хэвлэл). Артсофт.
2. Батчулуун, Б. (2004) *Философи гэж юу вэ?* (нэгдүгээр хэвлэл). Эдмон.
3. Отгонбаяр, М. (2005). *Метафилософи зарим эргэцүүлэл* [Илтгэлийн материал]. Дэлхийн философийн өдөрт зориулсан эрдэм шинжилгээний бага хурал, Улаанбаатар, Монгол.
4. Отгонбаяр, М нар. (2021) 1990 оноос хойш үе дэх Монголын философийн сургалт, судалгаан дахь онол, арга зүйн өөрчлөлтийн үйл явц, сургамж. *Философи, шашин судлал*. 23(551). 45-53.
5. Цэрэн, Г. (2012) *Философи гэж юу вэ*. *Философи Шашин Судлал*, 371(65),
6. 39 - 45.

Abstract:

Over the past 50 years of the Mongolian People's Republic's history, and within the initial 30 years of Mongolia's history, spanning the 80-year existence of the National University of Mongolia (NUM), the aim of this article is to investigate changes in philosophy, research, and methodology during this specific timeframe. In this context, the examination of philosophy in Mongolia is categorized into two periods—pre and post the 1990s. The analysis covers the shift from the dominant Marxist-Leninist philosophy, encompassing dialectical and historical materialism before 1990, to the current content of the philosophy curriculum in higher educational institutions in Mongolia. Furthermore, the update of the bachelor's and master's philosophy programs at NUM has been explored through the lenses of meta-philosophy, theoretical philosophy, and the history of philosophy.